



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 24 өдөр

Дугаар А/231

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ын "н" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Жаргалант сумын нутаг дэвсгэр /ойн бүс болон бусад газар/-т барилгын үйл ажиллагаа эхлүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зөвшөөрөл, зураг, төсвийг магадлалаар баталгаажсан эсэх, өмнө нь барилга байшин, газар доорх шугам сүлжээ барьсны улмаас эвдэгдсэн зам талбайг нөхөн сэргээлт хийгдсэн эсэхийг шалгах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Т.Жаргалсайхан - Аймгийн Засаг даргын орлогч

Гишүүд: С.Гантөмөр - Жаргалант сумын Засаг дарга

П.Эрдэнэчулуун - Мэргэжлийн хяналтын газрын дарга

Э.Дөлбадрал - Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын дарга

Ц.Чанцал - Мэргэжлийн хяналтын газрын Улсын байцаагч

З.Өмиртай - Газрын харилцаа барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга

Д.Бөхболд - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

П.Цэцэгсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Д.Эрдэнэбат

- Газрын харилцаа барилга, хот
байгуулалтын газрын мэргэжилтэн

2. Иргэн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд ажлыг зогсоох, эрх бүхий байгууллагад мэдэгдэж арга хэмжээ авч ажиллахыг ажлын хэсгийн ахлагч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

